



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/319

Чингис хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, 14.7 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны 2020 оны 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын нутаг дэвсгэрт Хэрлэн нэртэй 66.24 га талбайд “Өндөрхаан тохижилтын газар”-т Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар /Б.Дархантөр/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Батноров сумын Засаг дарга /Г.Тайванжаргал/-д тус тус мэдэгдэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Хайгуулын ажлын төлөвлөгөөг хуулийн хугацаанд багтаан батлуулж, үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах, холбогдох тайлан мэдээг цаг тухайд ирүүлж ажиллахыг “Өндөрхаан тохижилтын газар”-т зөвлөсүгэй.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг чанд мөрдүүлж, үйл ажиллагааны явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Байгаль, орчин аялал жуулчлалын газар /Б.Дархантөр/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА